

## “ГУДАМЖНЫ ХАНДЛАГАТАЙ ХҮҮХДҮҮД” СУДАЛГААНЫ ОРШИЛ ЭРГЭЦҮҮЛЭЛ

**А.АМАРСАНАА**

*МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим  
[am\\_sanaa@num.edu.mn](mailto:am_sanaa@num.edu.mn)*

*Түлхүүр үг: хүүхэд, гудамж, нэрлэх, тодорхойлох, ангилах*

**ТОВЧ АГУУЛГА.** Энэхүү судалгаанд 2001 онд Улаанбаатар, Дархан хотууд болон Сэлэнгэ аймгийн “Гудамжны” гэгдэх хүүхдүүдийг хамруулсан ба хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэсэн. Тус үзэгдэлд хамрагдаж байгаа хүүхдүүдийн хоорондын ялгаатай тал болон тэдний өөрсдийнх нь дотоод ертөнцийг харуулахыг оролдлоо. Манай улсад ажиглагдаж буй энэхүү үзэгдлийг Хятад, Бразил зэрэг орнуудтай харьцуулан нэрлэх, ангилах нэр томъёон дээр дүгнэлт гаргасан. Эцэст нь “гудамжны хүүхэд” үзэгдэлд антропологийн шинжлэх ухааны үүднээс ангилал гаргав.

Энэ өгүүллийг 2001 онд хийсэн магистрын ажлын судалгаан дээр тулгуурлаж бичлээ. Тус судалгаа нь антропологийн шинжлэх ухааны шинэ салбаруудын нэг хүүхдийн антропологийн салбарт хамаарагдана. Судалгааны ажлыг антропологийн судалгааны үндсэн арга болох “participant observation” буюу “оролцон ажиглах” аргаар хийсэн.

Судалгааны ажил хоёр хэсгээс бүрднэ. Нэгдүгээр хэсэгт хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагуудын<sup>1</sup> үйл ажиллагаа, тэдний зорилго, зарчим, хандлагыг тодорхойлохыг оролдсон болно. Хоёрдугаар хэсэгт судалгааны гол объект болох гудамжаар сэлгүүцэж эсвэл гудамжинд ажиллаж байгаа тэрчлэн гудамжинд амьдарч байгаа хүүхдүүдийг хамруулсан болно. Энэ үзэгдэлд хамрагдаж байгаа хүүхдүүдийн хоорондын ялгаатай талыг харуулахыг оролдлоо. Судалгааны ажиглалтуудыг Улаанбаатар, Дархан хотууд болон Сэлэнгэ аймагт хийлээ. Улаанбаатар хотод судалгаанд хамрагдсан хүүхдүүд нь худалдааны захууд, их дэлгүүрийн ойролцоох газрууд, галт тэрэгний буудал, Шархадны орчмоор оршиж байсан болно. Тэрчлэн Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн зарим халамжийн төвүүдэд амьдарч байсан

<sup>1</sup> Английн Хүүхдийг ивээх сан  
Скаутын холбоо  
Хүүхдийн төлөө үндэсний хороо  
Хүүхдийг хамгаалах сургалтын төв  
Энэрэл Буяны эмнэлэг  
ЮНИСЕФ

хүүхдүүдийг хамрууллаа. Судалгааны явцад нийт зуугаад хүүхдүүдтэй ярилцлага хийснээс арваад хүүхдүүдтэй илүү дотно харилцаа үүсгэж чадсан юм. Нийт хүүхдүүдийн насны байдлыг авч үзвэл 7-23 настай байснаас охидууд нь 13-16 насных байлаа. Бидний ажлын гол зорилго нь энэ үзэгдлийн нарийн учрыг ойлгож аль болох сэтгэлийн хөдөлгөөнөөр бус, бодит байдлын талаар үнэн зөв (objectif) дүгнэлт хийхэд оршино. Тэрчлэн энэ үзэгдлийн талаар нийтийн үзэл бодол болон мэдээллийн хэрэгслүүдээр өгөгдөж байгаа ойлголтуудаас аль болохоор зайлсхийхийг хичээлээ. Тэдгээр хүүхдүүд нь нийгмийн нэг хэсэг учраас тэдний хэлсэн болон хийснээс өөрсдийнх нь дотоод ертөнцийг (байдлыг) ойлгох хэрэгтэй гэж үзсэн болно. Хүүхдүүд өөрсдөө гудамжны нөхцөл байдлыг хэрхэн ойлгодог асуудал бидний анхаарлыг татаж байсан юм. Энэ нь тэднийг гудамжтай хэрхэн холбогдсоныг ойлгож тэрчлэн эргээд тэднийг нийгэмшихэд тус болж болох талтай.

Өсвөр насны хүүхдүүд болон залуучууд гудамжинд амьдардаг явдал зөвхөн Монгол оронд байдаг асуудал биш юм. Олон жилийн өмнөөс Африк, Латин Америк, Өмнөд Азийн орнуудад энэ үзэгдэл маш ихээр газар авч эхэлсэн байна. Мөн хөгжингүй орнуудын хувьд ч бас ийм үзэгдэл байдаг. Харин энэ үзэгдэл хөгжиж буй орнуудад илүү сэтгэл түгшээсэн асуудал болж байна. Урьд нь социалист хэмээн нэрлэгдэж байсан орнуудаас ОХУ, Румын, Болгар зэрэг орнуудад шинээр гарч ирсэн болно. Эдгээр орнуудад “гудамжны хүүхдүүд” хэмээх нийгмийн гажууд үзэгдэл нь олны дунд олон нийтийн анхаарлыг татах болжээ. Тэрчлэн хүүхдүүддээ их анхаарал тавьдаг Хятад орны хувьд ч энэ үзэгдэл байдаг байна. Энэ нь тус үзэгдэл зөвхөн улс төр, нийгэм, эдийн засгийн асуудал биш мөн орчин үеийн хотжилттой илүү холбоотой болохыг харуулж байна.

Энэ үзэгдэл бий болсон даруйдаа эхлээд сэтгүүлч, сурган хүмүүжүүлэгч нарын хүрээнд яригддаг байв. Аажмаар сурган хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтнууд, нийгмийн мэргэжилтнүүдийн хийсэн судалгааны ажил, тэдний бичсэн өгүүллүүд хэдэн арваараа бий болж энэ үзэгдэл эрдэмтдийн анхаарлыг татах болсон байна. Тиймээс энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлыг дурьдвал дуусашгүй билээ. Хүмүүнлэгийн шинжлэх ухааны чиглэлээр хийгдсэн тэдгээр судалгаанууд “Картала” (Kartala) хэвлэлээр цуврал ном болон гардаг.

Монгол орны хувьд энэ үзэгдэл арваад жилийн өмнөөс яригдах болсон байна. Энэ үеэс манай гудамжны хүүхдүүдийн тухай гадаадын сонин, сэтгүүлд ихээр бичих болов. Энэ үзэгдэл манай улс төр, эдийн засгийн гэнэтийн

өөрчлөлтийн явцад гарч ирснийг уншигчид андахгүй бизээ. Монгол оронд шинээр гарч ирсэн гудамжны хүүхдүүдийн тухай бидний ойлголт зөвхөн сонин сэтгүүлийн мэдээлэл болон барагцаалсан ойлголтоос хэтрэхгүй байна. “Гудамжны хүүхдүүд” гэсэн сэдвээр халамжийн төвүүдийн өөрсдийнх нь хийсэн судалгаанууд байдаг боловч тэдгээр нь олны хүртээл тэр болгон болоогүй байна.

Антропологийн онцлог аргыг хэрэглэсний үр дүнд бид “гудамжны хүүхэд” үзэгдлийн дотоод ертөнцтэй танилцах боломжтой. Энэ нь дээр дурьдсан судалгаануудаас илүү гүнзгий ойлголтыг бий болгох боломжтой юм. Энэ тоймолсон оршлын дараа тус өгүүлэлд гудамжны хүүхдүүдийг хэрхэн нэрлэх (marks, stigmata) болон ангилах (category) талаар уншигч танд танилцуулах болно. Үүний тулд, юуны өмнө бид нар монгол, хятад, бразил зэрэг орнуудад эдгээр хүүхдүүдэд оноож өгсөн нэр томъёотой танилцаж тэдгээрт дүн шинжилгээ хийнэ. Дараа нь хүүхдийн төгс төрх (ideal) энэ үзэгдэлтэй хэрхэн харьцуулагдсан байдлыг сонирхох болно. Эцэст нь “гудамжны хүүхэд” үзэгдлийг антропологийн шинжлэх ухаанд хэрхэн ангилдаг талаар авч үзнэ. “Гудамжны хүүхэд” үзэгдлийн шинж чанар нь тухайн орныхоо нийгэм, соёлын онцлог байдлаас шалтгаалан хоорондоо ялгаатай байдаг ч мөн нийтлэг шинжийг агуулсан байдаг. Тиймээс нэрлэх болон ангилах байдал нийтлэг шинжид хамаарагдна.

### **Нэрлэх хэв маяг**

Манайд эдгээр хүүхдүүдийг олон янзаар нэрлэдгийг та бүгд мэднэ. “Гудамжны хүүхэд” гэгдэх нэр томъёог анх сонин сэтгүүл, зурагтаар хэрэглэж ирсэн нь олны түгээмэл хэрэглээ болон хувирсан байна. Энэ үзэгдэл урьд нь манай оронд байгаагүй учраас тэднийг нэрлэж байгаа байдал сонирхол татаж байгаа юм. Энэ бүлэг хүүхдүүдийг оноож нэрлэхэд (desination) сөрөг утга заадаг үг хэллэг ашигладаг байдлаараа тус үзэгдэл байдаг аль ч орны хувьд ижил юм. Нэрлэж байгаа байдал нь эдгээр хүүхдүүдийн амьдралын аль нэг хэв маягт илүү тулгуурласан байдаг. Гэхдээ бид нар нэрлэж байгаа явцыг ярианы хэл болон бичгийн хэлнийх гэж хоёр хувааж болно. Ярианы хэлэнд шинээр бий болсон оноосон нэр нь тэр хүүхдүүдийн амьдралын нэгэн хэв маягийг гаднаас нь харж нэрлэсэн байна. Жишээлбэл, Монголд тэдгээр хүүхдүүдийг траншей буюу халуун усны шугамаас гарахыг харж “траншейны хүүхдүүд”; хуулийн дагуу сургуульд сурахын оронд гудамжинд байхыг харж “тэнэмэл хүүхдүүд”; хийдэг

ажлаар нь “хогийн хүүхдүүд” гэх мэтээр нэрлэсэн байна. Эдгээр оноосон нэрүүд нь энэ хүүхдүүдийн гадаад шинжүүдийг илэрхийлж байна.

Харин бичгийн хэлэнд хэрэглэдэг “амьдралын бололцоогүй хүүхэд” буюу “амьдралын гачигдалтай хүүхэд” эсвэл “орон гэргүй хүүхэд” гэх мэтээр нэрлэсэн байдаг нь тэдний амьдралд эдийн засгийн байдал хангалттай бус эсвэл орон гэр байхгүй гэсэн санааг илэрхийлж байна. Бичгийн хэлэнд давамгайлж байгаа утга нь дутмаг буюу эсвэл огт байхгүй гэсэн санааг илэрхийлж байгаа нь тэдгээр хүүхдүүдийг жирийн амьдралд амьдарч байгаа хүүхдүүдтэй харьцуулсан нь ойлгомжтой байна. Мөн сурган хүмүүжүүлэгчдийн судалгаа, тэдгээр хүүхдүүдэд ямар нэгэн хяналтын болон сурган хүмүүжүүлэх байгууллага дутагдаж байгааг илүү онцолсон байна. Жишээ татвал “хараа хяналтгүй хүүхэд” эсвэл “сургуулиас завсардсан хүүхэд” гэх мэтээр нэрлэсэн байдаг. Үүнээс үзвэл сурган хүмүүжүүлэгчид тэдгээр хүүхдүүдэд сурч боловсрох явдал дутагдалтай байгааг түлхүү харуулахыг оролдож байна. Энэ бүлэг хүүхдүүдийг оноож нэрлэхэд бичгийн хэлэнд хэрэглэдэг нийтлэг арга нь дутуу дулимаг гэсэн сөрөг шинжийг агуулсан байна. Яриа болон бичгийн хэлэнд нэрлэх хэв маяг нь хоорондоо ялгаатай байгаа ч гэсэн уг нэр томъёонууд нь сөрөг утга санааг агуулж байдгаараа тус үзэгдэл байдаг аль ч орны хувьд ижил байна. Эдгээр нэр томъёонуудыг харахад хүүхдүүдийн дотоод мөн чанарыг огт тусгаагүй зөвхөн гадаад өнгөөр нь эсвэл ямар нэгэн зүйл хэрэгцээтэй гэсэн байдлаар дүрсэлсэн байна.

Эдгээр нэр томъёонууд нь биеэ даасан нийгмийн зүгээс өгөгдсөн сөрөг утгатай учраас антропологийн шинжлэх ухааны концепт болоход учир дутагдалтай юм. Тэгэхлээр бид нар энэ өгүүлэлд тэдгээр хүүхдүүдийг “children in the situation of street” буюу “гудамжны хандлагатай хүүхдүүд” гэж нэрлэхийг илүүд үзсэн болно. Энэ нэр томъёог Шведийн эрдэмтэн Д.Стоеклан (D.Stoecklin) санал болгосон бөгөөд энэ үзэгдлийг ойлгоход тохиромжтой томъёо мэт санагдана. “Гудамжны хандлагатай хүүхдүүд” гэдэг нь хүүхэд гудамжтай янз бүрийн түвшинд холбогдож байдгийг илэрхийлж байгаа юм. Энэ нь тэдгээр хүүхдүүдийн сэтгэхүй, дотоод бодол, чадвар тэрчлэн тэдний гудамжинд өнгөрүүлсэн амьдрал, тэдэнд олон нийтийн зүгээс хандаж байгаа хандлага зэргээс шалтгаална.

Оноосон нэрийн талаар бусад орны хувьд ч ийм асуудал гардаг байна. Манай хөрш Хятад оронд энэ бүлэг хүүхдүүдийг нэрлэдэг олон хувилбар байдаг

байна. Д.Стоекланы багцалснаар “тогтворгүй хүн ам” (лиюдонг генгоу)<sup>2</sup>, “гаднаас ирэгчид” (ваидилаидэ), “сохор тэнүүлчид” (манглию), “хулиган” (лиюманг), “гудамжны хүүхэд” (лиюланг ертонг) гэх мэт оноосон нэрүүдийг дурьдаж болох юм. Лиюдонг бол тогтворгүй болон хууль бус гэсэн утга илэрхийлж байхад ваидилаидэ төлөвлөгөөт бус гэсэн утга агуулдаг байна. Энэ нь Хятадын гэр бүлд ноогдуулсан хүүхдийн тооны хязгаарлалттай холбоотой юм. Хууль зөрчигдөж төрсөн хүүхдүүд гудамжруу түрэгддэг явдал их байна. Бичгийн хэлэнд “буруу нийгэмшсэн хүүхэд” гэж тэднийг нэрлэсэн байна. Эндээс харахад бас л тэдгээр хүүхдүүдийг гадна талаас нь харж дүгнэсэн ойлголт олон нийтийн дунд байдаг нь тодорхой харагдаж байна. Харин Бразилд эдгээр хүүхдүүд гудамжтай илүү холбогддог нь энэ орны соёлын хэв шинжтэй холбоотой болох нь гарцаагүй юм. Гудамж бол нийтийн талбар юм. Гэтэл гудамжийг эдгээр хүүхдүүд байнгын байдлаар эзэмшдэг учраас түүнийг нийгмийн нэг хэсэг өөрийн болгож байна гэсэн утгаар тэднийг “гудамжны хүүхдүүд” гэж нэрлэх болсон байна. Энэ бүгдээс дүгнэхэд нэрлэх хэв маягийн нийтлэг байдал аль ч орны хувьд сөрөг шинж чанартай утгыг агуулдаг байна. Эдгээр оноосон нэрүүд тэдгээр хүүхдүүдийн тодорхойлолт (marks) мэт хэрэглэгдэх болсон. Нэг үгээр хэлбэл, оноосон нэрүүд нь тэднийг төлөөлсөн тогтсон хэв шинж мэт хэрэглэгддэг байна. Энэ тогтсон хэв шинж хүүхдийн төгс төрхийн нөлөөн дор улам батжиж өгдөг.

**“Хүүхдийн төгс төрх” болон “гудамжны хүүхэд” хэмээх үзэгдэл хоёрын харьцуулалт**

“Гудамжны хүүхэд” хэмээх үзэгдэл сэдвээр хийсэн олон судалгаануудаас харахад тэдгээр хүүхдүүдийг гудамжны хүчирхийлэлд автагдсан гэдэг утгаар илүүтэйгээр бичсэн байдаг. Гудамж хүүхэд хоёрын холбоо юуг харуулж болох вэ? Гудамж бол эрх чөлөөтэй орчноос гадна аюултай газар гэж тооцогддог. Энд амьдарч байгаа хүүхдүүд гудамжны муу нөлөөнд гүнзгий автах боломжтой байдаг. Тиймээс энд амьдарч байгаа хүүхдүүд аюултай бүлэг мэт ойлгогддог байна. Нийгэмд тогтсон хүүхдийн нэгэн хэвийн загвар болох гэнэн цайлган, амирлангуй төрхтэй тэд нарын гадаад байдал, амьдралын хэв маяг нийцдэггүй байна. Хүүхдийн төгс төрх (ideal) “гудамжны хүүхэд” үзэгдэлд хэрхэн нөлөөлдгийг сонирхоцгооё. “Гудамжны хүүхэд” нь аль ч нийгэмд сөрөг утгаар тодорхойлогдсон байдгийг бид дээр үзсэн. Энэ нь тухайн орны хүүхдийн төгс

<sup>2</sup> англиар галигласныг монголоор хөврүүлэв

төрхтэй харьцуулагдаж улмаар энэ ойлголт нь батжиж өгдөг. Тухайлбал, Хятад оронд хүүхдийн төгс төрх нь "сахилга баттай, бүтээлч, хүмүүжилтэй" гэдгээр тодорхойлогддогийг Стоеклан тэмдэглэсэн байна. (х, 54). Мөн Жо Боуден (Jo Boyden) европ хүүхдийн төгс төрхийг бичихдээ "хүүхэд хүний амьдралын нэг үе шат болох зовлонгүй, санаа сэтгэл тайван, баяр баяслыг өөртөө шингээсэн байдаг" гэжээ. Төгс төрх нь тухайн орны соёлын онцлогоос хамаарч, тухайлбал Азид номхон дөлгөөн, дуулгавартай занг эрхэмлэдэг байхад Европт сэтгэл зүйн талыг илүү анхаардаг байна. Төгс төрх нь агуулгын хувьд өөр өөр байдаг боловч аль ч нийгэм өөрийн төгс төрхтэй байдгийг эндээс харж болох юм. Төгс төрх нь нийгэмд амьдралын загвар болж хэрэглэгддэг. Тиймээс хүүхэд байх ёстой газраасаа өөр газар байвал тэднийг нийгэмд буруугаар авч үздэг. Хятад оронд гудамжны хүүхдүүдийг төгс төрхтэй харьцуулж үздэг байна. Тэдний гудамжнаас олж авсан төрх нь төгс төрхтэй огт тохирдоггүй байна. Хүүхэд эцэг эхийнхээ хараа халамжинд бойжиж сурч боловсрох ёстой байдаг энэ загвараас тэдгээр хүүхдүүдийн амьдрал өөр байна. Хэрэв хүүхэд нийгэмд байх ёстой байрандаа байгаагүй бол (out of place) хүүхдийн төгс төрхийн дагуу тэднийг олон нийт гажууд хүүхэд гэж авч үздэг. Гажууд хүүхэд гэдэгт хүүхдийн төгс төрхтэй нийцдэггүй хүүхдүүдийг хамруулдаг байна. Дээрхи үзэл нь энэ үзэгдэл байдаг аль ч орны хувьд хүчин төгөлдөр юм. Гажууд гэсэн санаанд хүүхдийн өөрийнх нь нийгмийг ойлгож буй ойлголт болон гудамжинд байгаа хугацаа, өдөр тутмын амьдралын ялгаатай талууд огт тусгагдаагүй байна. Тэрчлэн тус санаа нь нийгэмд хэрэглээ болдгийг дараахь жишээнээс харцгаая. "Шанхай хотын Пудон дүүргийн статистикийн мэдээнд 1994 оны эхний хагаст энэ дүүрэгт гарсан гэмт хэрэг, зөрчлийн 73.2%-ийг гудамжны хүүхдүүд үйлдсэн гэж дурьдсан байна". Энэ мэдээнээс гудамжны хүүхдүүд аюултай бүлэг болохыг харуулж байгаа боловч эдгээр гэмт хэргүүд гарсан газруудыг тодорхой мэдээлээгүй учраас тэр хэргүүдийг үнэхээр гудамжны хүүхдүүд хийсэн гэдэг нь эргэлзээтэй байгаа юм. Магадгүй хэрэг гарсан ихэнх газарт гудамжны хүүхдүүд нэвтрэх ямар ч боломжгүй байж ч болох талтай. Тэгэхээр эдгээр хүүхдүүдийн тухай нийгэмд тогтсон сөрөг ойлголт нь ийм мэдээлэл гаргах боломж олгож байна. Тэдний гэр бүлийн хүрээнд болон гудамжинд тохиолдож байдаг элдэв бэрхшээлүүд нь ихэнхдээ ижилдүү байдаг учраас эдгээр хүүхдүүдийг нэгэн төрөл бүлэг байгаа мэтээр ойлгох болсон байна. Энэ нь тус үзэгдлийн дотоод мөн чанарыг ойлгоогүйн улмаас гудамжинд нэг л төрөл хүүхэд байдаг гэж авч

үздэг нь алдаа болно. Ингээд дараах хэсэгт энэ үзэгдэлд хийгддэг ангиллын талаар сонирхоцгооё.

### “Гудамжны хүүхэд” болон “гудамжин дахь хүүхэд” ангилал

Олон улсад сурган хүмүүжүүлэгчдийн хийсэн судалгаанаас харахад эдгээр хүүхдүүдийг нэг талаас сэтгэл санааны болон биеийн хүчирхийлэлд өртөж хаягдсан гэж тайлбарласан байдаг. Нөгөө талаас эдийн засгийн бэрхшээлээс болж гудамжинд гарч ирсэн гэж үздэг. Тэгэхээр ийм нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүд дээрх хоёр үзэлд хуваагддаг байна. Тус хоёр үзэл нь хоёулаа *хохирсон* гэсэн санааг агуулж байна. Тэдний гудамжинд амьдрах болсон шалтгааныг зөвхөн ядуурал болон гэр бүлийн бэрхшээлээр тайлбарласан байна. Хэдийгээр эдгээр хүчин зүйлүүд энэ үзэгдэлд байгаа боловч бодит байдлын бүрэн тусгал нь болж чадахгүй юм. Эдгээр хүчин зүйлүүд байдаг нь үнэн боловч зөвхөн энэ үзэгдлийг нэг талаас харж байгаа нь шүүмжлэлтэй юм. *Хохирсон* гэсэн санаанд хүүхдийн чадварыг огт тусгаагүй байна. Дээр дурдсан хүчин зүйлүүд нь хүүхдийн нийгэмд хандаж байгаа хандлагыг бүрэн тайлбарлаж чадахгүй. Гэтэл энэ мэтийн нэгэн төрлийн шинж чанарын цаана нийгэм, эдийн засаг, улс төрийн олон асуудал зэрэгцэн оршиж байдаг юм. Хүүхдүүд гудамжинд гарч байгаа явдал нь зөвхөн эцэг эхийн хариуцлагын асуудал мэт авч үзэж байна. Хүүхдүүд гудамжинд гарч байгаа явдал нь зөвхөн хүүхэд –гэр бүл хоёрын хоорондын асуудал биш бас нийгэм, улс төр, эдийн засгийн асуудал болох ёстой.

Хүмүүнлэгийн шинжлэх ухааны судалгаагаар эдгээр хүүхдүүдийг хоёр зэрэгцсэн ойлголтын ангилалд хувааж үздэг: “*гудамжин дахь хүүхэд*” (children in the street) ба “*гудамжны хүүхэд*” (children of the street). Энэ ангилал нь 80 оны эхээр хүмүүнлэгийн шинжлэх ухаанд гарч ирсэн. Нэгэн судлаачийн бичсэнээс жишээ татвал “жинхэнэ гудамжны хүүхэд гэдэг нь орох оронгүй ганцаараа эсвэл яг өөртөөгөө адилхан хүүхдүүдтэй амьдардаг тийм хүүхдүүдийг хэлнэ” гэжээ. Харин “гудамжин дахь хүүхэд” гэдэг нь “гол төлөв гудамжинд ажилладаг хүүхдүүд багтдаг” гэж Блан (C.S.Blanc) бичсэн байна. Тэгэхээр “*гудамжин дахь хүүхэд*” ангилалд гудамжинд ажиллаж орой нь гэртээ харьдаг хүүхдүүд хамаардаг байхад “*гудамжны хүүхэд*” ангилалд гудамжинд байнга амьдардаг бөгөөд гудамж нь тэдний хувьд амьдрах цорын ганц орчин нь болдог хүүхдүүд багтдаг байна. Гэхдээ энэ ангилал нь тухайн үзэгдлийг бүрэн ойлгоход хангалтгүй юм. Яагаад гэвэл энэ ангиллын гол хүчин зүйл нь хүүхдүүд эцэг эхтэйгээ холбоотой болон холбоогүй байдаг эсэх эсвэл гудамжинд байнга

амьдардаг эсэх дээр тулгуурласан байна. Мөн энэ нь ангилалын шинжтэй хуваалт болохоос биш, ойлголтын шинжтэй хуваалт байж чадахгүй байна. Тэрчлэн тус ангилал явцуу бөгөөд хувь хүний санаа бодол тусгагдаагүй байна. Гэтэл хүүхдүүд өөрсдийнхөө байгаа байдлын талаар өөр өөр ойлголттой байдаг бөгөөд гудамжтай холбогдож байгаа байдал нь ч бас өөр өөр байдаг. Хүүхэд болгоны гудамжинд амьдарсан хугацаа, хэв маяг, нийгэмтэйгээ харьцаж байгаа харьцаа өөр өөр байдаг. Нийгэмших явц нь түүний гудамжинд өнгөрүүлсэн амьдралаас хамаардаг зүйл юм.

Мөн Монгол орны хувьд авч үзэхэд дээрх хоёр хэлбэрийн ангилалт тохирохгүй харин өөр ангилалт хэрэгтэй байдаг. Тэнэж байгаа хүүхдүүдийг гаднаас нь хараад дотор нь ялгалт хийхэд хэцүү байдаг ч судалгаа хийсний үр дүнд тэднийг бүгдийг нь нэг бүлэгт багтааж болохгүй нь тодорхойлогддог. Жишээлбэл, тэдний зарим нь эхийгээ буюу эцгийгээ дагаж гудамжинд хамт амьдардаг. Эдгээр хүүхдүүдийн хувьд эцэг эхийн хяналт огт байхгүй гэж үгүйсгэж болохгүй. Нөгөөтэйгүүр зарим хүүхдүүд өглөө нь сургуульдаа явж үлдсэн цагт нь гэр бүлийнхээ эдийн засагт нэмэр оруулахаар гадаа өдрийг өнгөрөөдөг. Эдгээр хүүхдүүд мөн л бусад гудамжинд амьдарч буй хүүхдийн адил нэг хэв маягийн замыг туулж, хийдэг зүйл нь бас нэг маягийнх байна. Тэдний хувьд гудамжны талаар ойлголт бусадтай адил тогтсон байдаг. Мөн манайд хүүхдүүд ахыгаа буюу эгчийгээ дагаж гудамжинд сэлгүүцдэг явдал маш олон байдаг. Монголд зарим тохиолдолд хүүхдүүд эцэг эхээсээ илүүгээр ах эгчээсээ имээдэг үе олон тохиолддог. Энэ нь тэдгээр хүүхдүүдийн хувьд ах, эгчийн нөмөр нөлөө тусдагийг харуулж байна. Эдгээр тохиолдлууд Блан-ы гаргасан ангилал манай нөхцөлд тохирохгүй байгааг харуулж байна.

Өнөөдөр "гудамжин дахь хүүхэд" болон "гудамжны хүүхэд" гэдэг ангилалт (category) нь улам нарийсаж онолын хүрээнд тавигдах болсон. Бразилийн нэрт эрдэмтэн Р.Луччини (R.Lucchini) Монтевидео (Аргентин) болон Рио-де-Жаниеро (Бразил) хотуудад хийсэн судалгааныхаа үр дүнд ангиллын талаар илүү нарийн ухагдахууныг гаргаж ирсэн. Хүүхдүүд гудамжийг зөвхөн сөрөг байдлаар авч үздэггүй байна. Энэ нь тэд нар гудамжинд амьдрах чадварыг хэр зэрэг эзэмшиж байгаагаас хамаарах зүйл юм. Тиймээс тэдний энэ чадварыг нь судалж, гудамжны амьдралд /соёлд/ хэр зэрэг автсан болохыг мэдэж болно. Олон эрдэмтэд эдгээр хүүхдийн нийгэмших явц болон орчноосоо олж авсан чадварыг нь судалдаг. Нийгэмших явц нь - хүүхэд – нийгмийн бусад гишүүд – гудамж-гурвын идэвхтэй байдлаас шалтгаалдаг. Луччини үзэхдээ тус үзэгдэл маш олон



цогцолбор асуудлаас бүрддэг учраас тухай үзэгдлийг дүрслэлт болон онолын тодорхойлолт хоёрыг ялгахад улам хэцүү болж байна гэж бичжээ.

Бид ангилал хийхдээ гудамжинд гарч байгаа хүүхдийн өөрсдийнх нь идэвхтэй болон идэвхгүй байдал дээр тулгуурласан болно. Тэгвэл бид *шахагдаж, хавчигдаж гарсан хүүхэд* эсвэл *өөрөө шийдэж, зориглож гарсан хүүхэд* гэсэн шинжийг ажиглаж болно. Дээрх хоёр төрлөөр гудамжинд гарсан хүүхэд хоорондоо ялгагдах өвөрмөц онцлогтой байдаг. *Өөрөө шийдэж, зориглож гарсан хүүхэд* гудамжинд амьдрахдаа *шахагдаж, хавчигдаж гарсан хүүхдээс* илүү давамгай, арга ухаанаа олсон байдаг. *Шахагдаж, хавчигдан гэрээсээ дайжсан хүүхэд “гудамжин дахь хүүхэд”* гэдэг ангилалд илүү ойртож очдог бол, *өөрөө шийдэж, зориглож гарсан хүүхэд “гудамжны хүүхэд”* гэдэг ангилалд илүү ойртдог. Харин гудамжны тухай хүүхдийн ойлголт нь хувьсан өөрчлөгдөж, хөгжиж байдаг учраас тогтсон нэг ухагдахууныг хатуу баримталж болохгүй. Эдгээр хоёр ангилалын дотоод ялгаатай талыг доорхи хүснэгтээр харууллаа.

“Гудамжны хүүхэд” болон “гудамжин дахь хүүхэд” хоёрын ялгаатай талууд

Гудамжин дахь хүүхэд	Гудамжны хүүхэд
<i>Шахагдаж, хавчигдан гэрээсээ дайжсан хүүхэд</i> “	<i>Өөрөө шийдэж, зориглож гарсан хүүхэд</i>
Харъяат	Биеэ даасан
Дагалдагч	Манлайлагч
Гудамж түр зуурын газар	Байнгын оршин суугч
Гудамжны талаар сөрөг төсөөлөлтэй	Гудамжны талаар эерэг төсөөлөлтэй
Нийгмийн ёсыг таних	Гудамжны соёл

Хүүхдийн гэрээсээ дайжсан нөхцөл байдал, гудамжинд амьдрах арга ухаанаа олсон байдал, гудамжны талаар хийсэн дүгнэлт зэрэг нь түүний нийгэмшихэд өндөр үүрэгтэй. Бид “гудамжны хандлагатай хүүхэд” гэсэн ойлголтонд хүүхдийн өөрөө өөрсдөө өгсөн төрх буюу гудамжинд байх амьдралаа дүгнэсэн байдал болон тэдний гудамжны талаарх хувийн бодлыг хамааруулж байгаа юм. Тус ангилалын давуу тал нь хүүхдийн өөрсдийнх нь

чадварыг үнэлэх явдал юм. Хүүхэд зөвхөн том хүний захиргаанд оршдоггүй биеэ даасан бие хүн гэсэн санааг харуулж өгч байна. Уншигч танд энэ үзэгдлийн нэгэн хэсгээс толилууллаа. өгүүлэл тус авч үзсэн бөгөөд дараагийн өгүүлэлд хүүхдийн гудамжинд амьдрах стратеги талаас өгүүлэх болно.

## ТАЛАРХАЛ

ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн угсаатны зүйн багш И.Лхагвасүрэн нь тус өгүүлийг сонирхолтой бөгөөд улам төгөлдөр болгоход хүч чармайлтаа гарган ажилласан явдалд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлмээр байна.

## НОМ ЗҮЙ

- Английн хүүхдийг ивээх сангийн стратеги төлөвлөгөө 2000-2004.* 2004. Английн хүүхдийг ивээх сан. Улаанбаатар хот.
- Гудамжны болон гэр орноосоо дайжсан хүүхдийн судалгаа, 1999.* Хүүхэд хамгаалал төв
- Дунд хугацааны тодотгол: НҮБ-ын хүүхдийн сангийн хөёр дахь хөтөлбөр, 2000.* Монгол улсын Засгийн газар ба НҮБ-ын хүүхдийн сан. Улаанбаатар хот
- Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын хүүхдийн сангийн хамтын ажиллагааны стратеги уулзалт. 2000.* Монгол улсын Засгийн газар ба НҮБ-ын хүүхдийн сан. Улаанбаатар хот, Засгийн газрын ордон.
- Монголын хүний хөгжлийн илтгэл. 1997.* Монгол улсын Засгийн газар ба НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. Улаанбаатар хот, Адмон
- Монголын хүний хөгжлийн илтгэл. 2000.* Монгол улсын Засгийн газар ба НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. Улаанбаатар хот, Адмон.
- Монголын хүүхдийн байдал 1998. 1999.* Монголын хүүхдийн төлөө үндэсний төв. Улаанбаатар хот
- Монголын хүүхдийн төлөө сонин, 1999.* ЮНИСЕФ. 8 дугаар сар, 1999, №5.
- Нийгмийн хамгаалал, халамж, хүртээмж хөтөлбөрийн хараа хяналтгүй хүүхдүүдэд чиглэсэн төслүүд талаархи мэдлэг, хандлага, дадал, хэвшил, судалгааны тайлан.* Английн хүүхдийг ивээх сан. Улаанбаатар хот.
- Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөрийн үнэлгээний тайлан 1995-2000.* 2001. Английн хүүхдийг ивээх сан. Улаанбаатар хот, Боловсролын хөгжлийн сургуулийн хэвлэх цех
- Blanc C.S., 1994. Urban Children in Distress. Global predicaments and innovative strategies,* New-York, UNICEF
- Boyden, J., 1990. Childhood and the Policy Makers : a Comparative perspective on the globalization of childhood, in A. James & A Prout Constructing and reconstructing childhood., London : The Falmer Press, pp. 184-215*
- Floating population in Shanghai. 1996. In A perspervive of social transformation in China,* Shangai Academy of Social Sciences, manuscrit non publ.
- Lucchini, R., 1993. Enfant de la rue : identitit, sociabilitit, drogue, Genive/Paris : Droz.*
- Lucchini, R., 1996. Sociologie de la survie. L'enfant dans la rue, Paris : PUF.*
- Marguerat, Y., Poitou, D., 1994. A l'ycoute des enfants de la rue en Afrique Noire, Paris : Fayard.*
- Stoecklin, D., 2000. Enfants des rues en Chine, Paris : Karthala.*
- Tessier, S., (sous la direction de), 1998. A la recherche des enfants des rues, Paris : Karthala.*

## SUMMARY

A. Amarsanaa

### A draft study of the phenomenon "The children in the street"

This article has a principal goal to achieve against the prejudices on the phenomenon "children in the street of Mongolia". This reality was acted by the actors themselves and had given a contrast perception of children's images. These images don't correspond in the modern ideal-type admitted by the common sense. At first, the research concerns the different names of these children used in the speaking and writing.

A comparison to Stoecklin's topic in China, which permits more on understanding the relationship of this phenomenon with political, social and cultural factors. Usually these children are showed as victims and social deviants, proving their incapacity. Another thing is the expression "street children" which is so much mediatized and used commonly, so it will be impossible to use in the study of anthropology. It's necessary, indeed, to distinguish, at first the difference between "children of the street" and "children in the street". This study doesn't consider a child to be like prefigure of an adult, but tries to give an autonomy dimension of children in the universe, assigned in a social role.

## RESUME

### L'étude préliminaire du phénomène « Les enfants en situation de rue »

Cet article participe dans son but principal à mettre en doute les préjugés existants et le sens commun sur le phénomène des enfants en situation de rue en Mongolie. La réalité vécue par les acteurs même et la perception que les passants en donnent, renforcent le contraste de cette image de l'enfance qui ne correspond pas au modèle idéal-typique admis par le sens commun. L'analyse porte d'abord sur les différentes dénominations pour appeler ces enfants à la fois dans la langue parlée et la langue écrite en mongol. Une comparaison établie avec l'étude de Stoecklin sur ce sujet en Chine permet de mieux comprendre les liens de ce phénomène avec les facteurs politiques, sociaux et culturels. Considérant ces enfants comme les enfant-déviant et enfant-victime sont mis en fleur l'idée d'incapacité de ces enfants. Aussi, l'expression "enfants des rues", fortement médiatisée et communément utilisée, n'est pas opératoire.

Il est nécessaire en effet de distinguer, dans un premier temps, entre « enfants de la rue » et « enfants dans la rue ». Cette étude ne considère pas l'enfant comme une préfiguration de l'adulte, mais tente de donner une dimension autonome de l'enfant dans son propre univers, doté d'un rôle social.